




## НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого, ) 2015 онд 844.8 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 9.6 тэрбум төгрөгөөр буюу 1.1 хувиар илүү бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2014 оныхоос 4.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1. Төсвийн орлого, зарлага, тэрбум төгрөг



Төсвийн орлогын гүйцэтгэлийг бүтцээр нь авч үзвэл 551.6 тэрбум төгрөг буюу 65.3 хувь нь хууль тогтоомжийн дагуу нийслэлийн төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогын эх үүсвэрээс, 293.2 тэрбум төгрөг буюу 34.7 хувь нь тусламжийн орлого буюу улсын төсвөөс нийслэлд хуваарилах тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн орлогоос тус тус бүрдэж байна.

Хүснэгт 1. Нийслэлийн төсвийн нийт орлого, дүүргээр, сая төгрөг

	Нийт орлого		Үүнээс:					
	Бүгд	ТБ %	Татварын орлого		Татварын бус орлого		Тусламжийн орлого	
			Бүгд	ТБ %	Бүгд	ТБ %	Бүгд	ТБ %
Багануур	11447.5	96.3	633.0	102.0	323.9	94.9	10490.7	96.0
Багахангай	3233.6	92.9	82.9	108.6	143.0	117.3	3007.7	91.6
Баянгол	58122.5	99.2	12943.0	105.5	1195.0	92.3	43984.5	97.6
Баянзүрх	71686.0	97.5	13233.9	104.5	868.9	40.2	57583.2	98.0
Налайх	11927.8	97.0	601.2	93.1	241.4	114.3	11085.3	96.9
Сонгинохайрхан	61328.6	98.1	6155.0	101.8	807.6	96.7	54365.9	97.7
Сүхбаатар	70550.9	100.7	24623.9	105.4	705.7	70.5	45221.3	99.0
Хан-Уул	47384.5	95.9	16232.7	95.6	1787.5	68.6	29364.2	98.4
Чингэлтэй	59047.5	109.2	27064.7	132.3	1180.8	58.3	30802.0	97.5
Нийслэлийн шууд	450030.7	102.5	364724.7	99.1	78007.6	122.2	7298.5	97.5
Дүн	844759.6	101.1	466295.0	101.1	85261.4	114.6	293203.3	97.8

## Хүснэгт 2. Нийслэлийн төсвийн нийт орлого, 2015 онд, сая төгрөгөөр

Төсвийн орлогын нэр,төрөл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү, сая.төг
I. Нийт орлого ба тусламжийн дүн	835185.1	844759.6	101.1	9574.6
II. Орон нутгийн төсвийн нийт орлого	535502.8	551556.4	103.0	16053.6
III. Урсгал орлого	535502.8	551556.4	103.0	16053.6
IV. Татварын орлогын дүн	461075.6	466295.0	101.1	5219.4
Орлогын албан татвар	319619.2	323259.4	101.1	3640.1
Хүн амын орлогын албан татвар	319619.2	323259.4	101.1	3640.1
Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/	293502.5	291287.0	99.2	-2215.5
ХХОАТ-ын буцаан олголт	-24435.0	-24432.9	100.0	2.1
Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний	1818.4	1694.4	93.2	-124.0
Үйл ажиллагааны орлогын татвар	17440.0	21057.7	120.7	3617.7
Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогын татвар	3039.9	2898.3	95.3	-141.6
Хөрөнгө борлуулсны орлогын татвар	5915.7	5195.9	87.8	-719.8
Бусад орлого	22337.7	25559.0	114.4	3221.2
Өмчийн татвар	32126.3	33143.5	103.2	1017.2
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	32058.0	33026.7	103.0	968.7
Бууны албан татвар	68.3	116.8	171.1	48.5
Бараа ба үйлчилгээний татвар	22573.7	20551.8	91.0	-2021.9
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	22573.7	20551.8	91.0	-2021.9
Бараа үйлчилгээний бусад татвар	117.7	66.7	56.7	-51.0
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	117.7	66.7	56.7	-51.0
Бусад татвар, хураамж, төлбөр	86638.7	89273.6	103.0	2634.9
Улсын тэмдэгтийн хураамж	29508.5	32382.7	109.7	2874.2
Газар ашигласны төлбөр	40253.9	40809.3	101.4	555.5
Ус ашигласны төлбөр	2986.7	3027.2	101.4	40.5
Хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр	32.5	35.7	109.8	3.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12857.0	12537.3	97.5	-319.8
Нийслэл хотын татвар	1000.0	481.3	48.1	-518.7
V. Татварын бус орлогын дүн	74427.2	85261.4	114.6	10834.2
ААНБ-ын хувьцааны ногдол ашиг	1410.0	973.2	69.0	-436.8
Түрээсийн орлого	1553.4	1763.3	113.5	209.9
Төсөвт байгууллагын өөрийн орлого	9221.7	9008.0	97.7	-213.7
Хүү, торгуулийн орлого	24973.4	20871.9	83.6	-4101.5
Бусад нэр заагдаагүй орлого	4230.8	5468.2	129.2	1237.4
Автозам ашигласны төлбөр	10627.9	9663.6	90.9	-964.3
Өмч хувьчлалын орлого	22410.0	37513.2	167.4	15103.2
VI. Тусламжийн орлого	299682.3	293203.3	97.8	-6479.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	24576.8	20960.0	85.3	-3616.8
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	267384.4	263852.4	98.7	-3531.9
Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	7721.1	8390.8	108.7	669.7

Татварын орлогын хэмжээ энэ онд 466.3 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө төлөвлөснөөс 5.2 тэрбум төгрөгөөр буюу 1.1 хувиар илүү биелсэн бөгөөд орлогын голлох төрлүүдээр авч үзвэл 69.3 хувийг хүн амын орлогын албан татвар, 7.1 хувийг өмчийн татвар, 4.4 хувийг бараа ба үйлчилгээний татвар, 0.1 хувийг бараа үйлчилгээний бусад татвар, 19.1 хувийг бусад татвар, хураамж, төлбөр (улсын тэмдэгтийн хураамж, газар, ус, хэрэглээний мод түлээ ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж) эзэлж байна.


2015 онд 74.4 тэрбум төгрөгийн татварын бус орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 85.3 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын төлөвлөгөө 114.6 хувиар биелжээ. Татварын бус орлогын 24.5 хувийг хүү, торгуулийн орлого, 10.6 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 44.0 хувийг өмч хувьчлалын орлого, 11.3 хувийг авто зам ашигласны төлбөр, үлдсэн 9.6 хувийг ААНБ-ын хувьцааны ногдол ашиг болон бусад нэр заагдаагүй орлогууд бүрдүүлжээ.

Тусламжийн орлогын хэмжээ 293.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 6.5 тэрбум төгрөгөөр буюу 2.2 хувиар дутуу бүрдсэн байна. Тусламжийн орлогын 90.0 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 7.1 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн орлогоос, 2.9 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлогоос олжээ.

Нийслэл хотын нэг хүнд ногдох орон нутгийн төсвийн урсгал орлогын хэмжээ 2015 онд 414.7 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 2.4 хувиар, төсвийн урсгал зардлын хэмжээ 482.9 мянган төгрөгт хүрч 20.9 хувиар тус тус өссөн байна.

Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2015 онд 1 их наяд 32.3 тэрбум төгрөгөөр төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 883.8 тэрбум төгрөг зарцуулжээ.

Зураг 2. Төсвийн зарлагын бүтэц, хувиар



Орон нутгийн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн 26.2 хувийг цалин хөлс болон нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 29.6 хувийг бараа үйлчилгээний урсгал зардал, 16.8 хувийг татаас болон урсгал шилжүүлгүүд, 27.3 хувийг хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна. Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг өмнөх 2014 онтой харьцуулахад 8.5 хувиар буюу 69.1 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

### Хүснэгт 3. Улсын төсвийн нийт орлого, зарлага, бүсээр, сая төгрөг

	Төсвийн орлого			Төсвийн зарлага		
	2013 он	2014 он	2015 он	2013 он	2014 он	2015 он
БҮГД	1903077.4	2093967.6	2024836.8	1778736.8	2084468.8	2058487.3
Баруун бүс	280632.9	305854.3	282910.0	274672.3	307301.7	281615.5
Хангайн бүс	377130.6	411705.2	387284.2	346101.5	413449.8	390491.4
Төвийн бүс	369210.9	401221.4	360832.3	334800.9	426245.7	355328.1
Зүүн бүс	148401.3	162817.6	149050.7	141540.8	167333.6	147258
Улаанбаатар	727701.7	812369.1	844759.6	681621.3	770138	883794.3

### Хүснэгт 4. Нийслэлийн төсвийн нийт зарлага, сая төгрөг

Төсвийн зарлагын нэр, төрөл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү, сая.төг
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1032289.6	883794.3	85.6	-148495.3
I. Урсгал зардал	676343.4	642307.3	95.0	-34036.1
Бараа үйлчилгээний зардал	521903.2	493890.2	94.6	-28013.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211316.9	209186.8	99.0	-2130.1
Нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23407.7	22665.1	96.8	-742.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24689.1	24002.9	97.2	-686.2
Хангамж, бараа материалын зардал	47580.1	44213.2	92.9	-3366.9
Нормативт зардал	21465.9	20666.4	96.3	-799.5
Эд хогшил, урсгал засварын зардал	9273	8737.9	94.2	-535.1
Томилот, зочны зардал	2654.3	2537.3	95.6	-117.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	136609.4	119201.7	87.3	-17407.7
Бараа үйлчилгээний бусад зардал	44906.8	42678.9	95.0	-2227.9
Татаас ба урсгал шилжүүлэг	154440.2	148417.1	96.1	-6023.1
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	998.0	996.0	99.8	-2.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	68.0	67.0	98.5	-1.0
Нийгмийн халамжийн үйлчилгээ	90813	89295.7	98.3	-1517.3
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1128	1064.6	94.4	-63.4
Төрөөс иргэдэд үзүүлэх тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	49923.7	46350.6	92.8	-3573.1
Хүн амын тодорхой бүлэгт үзүүлэх дэмжлэг	11509.5	10643.2	92.5	-866.3
II. Хөрөнгийн зардал	355946.2	241487	67.8	-114459.2
Дотоод хөрөнгө оруулалт	344971	239388.6	69.4	-105582.4
Барилга байгууламж	219332.9	172795.7	78.8	-46537.2
Их засвар	109475.9	52509.8	48.0	-56966.1
Тоног төхөөрөмж	8189.5	5087.4	62.1	-3102.1
Бусад хөрөнгө	7972.7	8995.7	112.8	1023.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	10975.2	2098.4	19.1	-8876.8